МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 03 өдөр Дугаар А/268. Алтай хот

Цугларах, шилжүүлэх байрыг
шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Дайчилгааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5, 18.1.7, 18.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн дайчилгаагаар татагдан ирсэн бэлтгэл офицер болон цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнүүдийг аймгийн дайчилгааны даалгаврын дагуу Зэвсэгт хүчний ангиудад хуваарилан хүргэх, “Цугларах байр”-аар аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрыг, байрын даргаар тус байгууллагын даргыг, дайчлагдан ирсэн автотехник хэрэгслийг үзлэг оношлогоонд оруулан үүрэг гүйцэтгэхэд бэлтгэн Зэвсэгт хүчний ангиудад хувиарилан хүргэх “Шилжүүлэх байр”-аар аймгийн Авто тээврийн газрыг, байрын даргаар тус байгууллагын дарга нарыг тус тус томилсугай.

2.Цугларах, шилжүүлэх байрыг зааврын дагуу дэлгэх журмыг боловсруулан баталгаажуулж байрын бүрэлдэхүүнийг томилон сурган дадлагажуулахыг Цугларах, шилжүүлэх байрын дарга нарт, цугларах байранд ажиллах эрүүл мэндийн тасгийг шаардлагатай мэргэжлийн эмч нараар бүрдүүлэн томилохыг Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгийн дарга нарт тус тус хариуцуулсугай.

3.Цугларах, шилжүүлэх байрын томилгоот бүрэлдэхүүнтэй дадлага сургуулийг жилд 2 удаа зохион байгуулан мэргэжлийн удирдлагаар ханган ажиллахыг Цэргийн штаб (хурандаа Д.Төмөрбаатар)-т үүрэг болгосугай.

4.Тус захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн мн/02 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

C:/My documents/-3A-4 doc

9999999912